БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Толбо сумын Эрүүл мэндийн төсвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2024/155/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2023 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br><br>Аудитор: Б.Үүрийнтуяа<br>Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 13
4. АУДИТЫН ТАЙЛАН ..... 17
4.1 Ерөнхий зүйл ..... 17
4.2 Материаллаг байдал ..... 17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 18
4.5.1 Завсрын аудитын талаар ..... 18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 19
5.1 Төлбөрийн акт ..... 19
5.2 Албан шаардлага ..... 19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2024.02.16 № 147

танай ______ -ны № ______ -т

ТОЛБО СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
К.МОЛДАБЕК ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

**Аудитын гол асуудал**

Тус төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402170

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **107,461,739.68** | **112,436,678.17** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 25,408,544.00 | 18,447,373.29 |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| 31110 | Төгрөг | - | - |
| 31140 | Касс арилжааны банк | - | - |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 25,408,544.00 | 18,447,373.29 |
| **3121** | **Төгрөг** | 25,408,544.00 | 18,447,373.29 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 25,408,544.00 | 18,447,373.29 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | - | - |
| **33** | **АВЛАГА** | - | 27,344,443.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | - |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 27,344,443.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 82,053,195.68 | 66,644,861.88 |
| **351** | **Түүхий эд материал** | 55,504,707.64 | 33,086,016.64 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | - | - |
| 35130 | Эм боох материал | 55,504,707.64 | 33,086,016.64 |
| **354** | **Хангамжийн материал** | **26,548,488.04** | **33,558,845.24** |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | 1,089,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 22,176,193.04 | 26,860,910.24 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 347,500.00 | - |
| 35460 | Хүнсний материал | 4,024,795.00 | 5,608,935.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **676,876,465.25** | **1,069,109,352.42** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 676,876,465.25 | 1,069,109,352.42 |
| **392** | **Биет хөрөнгө** | 673,632,465.25 | 1,065,148,019.11 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 501,369,200.00 | 827,646,007.60 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (37,979,075.64) | (46,206,807.48) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 79,000,522.00 | 79,000,522.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (56,694,651.48) | (62,514,650.52) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 240,728,345.13 | 318,437,389.93 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (83,038,680.82) | (117,856,807.43) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 59,198,683.92 | 102,360,622.80 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (39,001,877.90) | (43,493,257.87) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 24,500,000.00 | 24,500,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (14,449,999.96) | (16,724,999.92) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 3,244,000.00 | 3,961,333.31 |
| 39301 | Програм хангамж | 850,000.00 | 1,730,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (750,000.00) | (912,666.69) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 3,144,000.00 | 3,144,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | - | - |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **784,338,204.93** | **1,181,546,030.59** |

| | | | |
|---|---|---|---|
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **413** | **Өглөг** | - | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | - |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | - |
| **4136** | **Бусад өглөг** | - | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | - |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **784,338,204.93** | **1,181,546,030.59** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 784,338,204.93 | 1,181,546,030.59 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 228,845,545.08 | 228,845,545.08 |
| 51101 | Өмч: - төрийн | 228,845,545.08 | 228,845,545.08 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 247,965,118.13 | 645,172,943.79 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (507,015,382.80) | 247,965,118.13 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 754,980,500.93 | 397,207,825.66 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 307,527,541.72 | 307,527,541.72 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **784,338,204.93** | **1,181,546,030.59** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **863,691,477.99** | **1,414,555,991.77** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **109,124,770.99** | **433,486,720.48** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 109,124,770.99 | 433,486,720.48 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 109,124,770.99 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 109,124,770.99 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | - | 415,962,291.28 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | - | 17,524,429.20 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **754,566,707.00** | **981,069,271.29** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,210,557.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 310,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 900,557.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 33,534,000.00 | 35,401,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 33,534,000.00 | 35,401,700.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 719,822,150.00 | 945,667,571.29 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 719,822,150.00 | 945,667,571.29 |

| | | | |
|---|---|---|---|
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **748,867,020.19** | **1,017,348,166.11** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **748,867,020.19** | **1,017,348,166.11** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 748,860,623.19 | 1,015,695,263.11 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 451,087,995.00 | 623,501,499.00 |
| 210101 | Үндсэн цалин | 280,763,214.00 | 381,003,396.00 |
| 210102 | Нэмэгдэл | 106,920,539.00 | 172,164,909.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,037,000.00 | 7,641,000.00 |
| 210104 | Урамшуулал | 55,367,242.00 | 62,692,194.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **57,199,446.00** | **80,644,400.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,762,371.00 | 54,838,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,360,838.00 | 6,451,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,488,530.00 | 5,161,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 911,959.00 | 1,290,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,675,748.00 | 12,903,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **30,248,103.00** | **31,188,297.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,699,703.00 | 2,765,805.00 |
| 210302 | Түлш, халаалт | 27,765,400.00 | 28,422,492.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 783,000.00 | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **53,288,620.00** | **69,451,412.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,069,450.00 | 6,096,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 36,038,200.00 | 43,053,750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,758,000.00 | 3,080,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,080,000.00 | 525,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,342,970.00 | 11,022,432.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 5,673,580.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 102,178,312.39 | 140,710,841.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 84,294,077.39 | 120,176,091.00 |
| 210502 | Хоол, хүнс | 10,494,235.00 | 13,500,250.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,390,000.00 | 7,034,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,990,700.00 | 4,246,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 60,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,990,700.00 | 4,186,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,107,400.00 | 2,804,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,107,400.00 | 2,804,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 402,228.00 | 638,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 13,100.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 48,300.00 | 80,960.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 9,388.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 526,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 31,440.00 | 31,440.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **48,357,818.80** | **62,509,914.11** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,340,697.00 | 6,715,010.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 39,017,121.80 | 55,794,904.11 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,397.00** | **1,652,903.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | - |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 6,397.00 | 1,652,903.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,397.00 | 1,652,903.00 |
| 213404 | Хөрөнгийн | - | - |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | - |
| 220001 | Барилга байгууламж | - | - |
| 221001 | Их засвар | - | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **114,824,457.80** | **397,207,825.66** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | - | - |
| 145003 | Хөрөнгө оруулалтын олз | - | - |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | - |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө | - | - |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал | - | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **114,824,457.80** | **397,207,825.66** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**Төгрөгөөр**

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **787,988,707.00** | **953,724,828.29** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **787,988,707.00** | **953,724,828.29** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | - | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,210,557.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 310,000.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 900,557.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 33,534,000.00 | 35,401,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 33,534,000.00 | 35,401,700.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 753,244,150.00 | 918,323,128.29 |

| | | | |
|---|---|---|---|
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 753,244,150.00 | 918,323,128.29 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **713,223,463.00** | **928,620,499.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **713,223,463.00** | **928,620,499.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **713,217,066.00** | **926,967,596.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 451,087,995.00 | 623,501,499.00 |
| 210101 | Үндсэн цалин | 280,763,214.00 | 381,003,396.00 |
| 210102 | Нэмэгдэл | 106,920,539.00 | 172,164,909.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,037,000.00 | 7,641,000.00 |
| 210104 | Урамшуулал | 55,367,242.00 | 62,692,194.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **57,154,942.00** | **80,644,400.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,762,371.00 | 54,838,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,360,838.00 | 6,451,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,488,530.00 | 5,161,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 867,455.00 | 1,290,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,675,748.00 | 12,903,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **30,595,603.00** | **30,840,797.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,699,703.00 | 2,765,805.00 |
| 210302 | Түлш, халаалт | 28,112,900.00 | 28,074,992.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 783,000.00 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 58,622,600.00 | 64,734,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,069,450.00 | 7,010,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 40,147,000.00 | 43,053,750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,758,000.00 | 3,080,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,154,000.00 | 525,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,494,150.00 | 11,064,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 96,646,401.00 | 112,327,290.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 72,482,861.00 | 89,303,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,605,540.00 | 15,084,390.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 12,558,000.00 | 7,939,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,535,200.00 | 4,462,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 60,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,535,200.00 | 4,402,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,107,400.00 | 2,804,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,107,400.00 | 2,804,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 402,228.00 | 638,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 13,100.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 48,300.00 | 80,960.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 9,388.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 526,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 31,440.00 | 31,440.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12,064,697.00 | 7,015,010.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,064,697.00 | 7,015,010.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,397.00** | **1,652,903.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | - |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 6,397.00 | 1,652,903.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,397.00 | 1,652,903.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **74,765,244.00** | **25,104,329.29** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | - | - |
| 140001 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | |
| 140002 | Улсын төсвөөс олгосон зээл | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **49,356,700.00** | **32,065,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **49,356,700.00** | **32,065,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 49,356,700.00 | 32,065,500.00 |
| 220001 | Барилга байгууламж | | |
| 221001 | Их засвар | | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 49,356,700.00 | 32,065,500.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(49,356,700.00)** | **(32,065,500.00)** |
| 14 | **Бусад эх үүсвэр** | - | - |
| 145004 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх | | |
| 145005 | Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх | | |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 25,408,544.00 | (6,961,170.71) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 25,408,544.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 25,408,544.00 | 18,447,373.29 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**Төгрөгөөр**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 228,845,545.08 | 307,527,541.72 | 247,965,118.13 | **784,338,204.93** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **228,845,545.08** | **307,527,541.72** | **247,965,118.13** | **784,338,204.93** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | | | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | - |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **228,845,545.08** | **307,527,541.72** | **247,965,118.13** | **784,338,204.93** |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **228,845,545.08** | **307,527,541.72** | **247,965,118.13** | **784,338,204.93** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **228,845,545.08** | **307,527,541.72** | **247,965,118.13** | **784,338,204.93** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | | | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 397,207,825.66 | **397,207,825.66** |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **228,845,545.08** | **307,527,541.72** | **645,172,943.79** | **1,181,546,030.59** |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**төгрөгөөр**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,007,790,400.00** | **959,033,096.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,007,790,400.00** | **959,033,096.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,007,790,400.00** | **959,033,096.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **644,150,100.00** | **623,501,499.00** |
| 210101 | Үндсэн цалин | 390,045,800.00 | 381,003,396.00 |
| 210102 | Нэмэгдэл | 166,948,800.00 | 172,164,909.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,228,000.00 | 7,641,000.00 |
| 210104 | Урамшуулал | 78,927,500.00 | 62,692,194.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **80,644,400.00** | **80,644,400.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 54,838,400.00 | 54,838,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,451,600.00 | 6,451,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,161,100.00 | 5,161,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,290,200.00 | 1,290,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,903,100.00 | 12,903,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 32,469,700.00 | 30,840,797.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,164,800.00 | 2,765,805.00 |
| 210302 | Түлш, халаалт | 27,304,900.00 | 28,074,992.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,000,000.00 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 71,035,600.00 | 64,734,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 7,682,500.00 | 7,010,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 46,846,400.00 | 43,053,750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,346,800.00 | 3,080,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,765,800.00 | 525,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,394,100.00 | 11,064,700.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | 118,604,400.00 | 112,327,290.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 92,178,300.00 | 89,303,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 17,342,100.00 | 15,084,390.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 9,084,000.00 | 7,939,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 41,918,700.00 | 35,647,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 19,700,000.00 | 17,920,000.00 |
| 210602 | Тавилга | 4,800,000.00 | 4,203,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 17,418,700.00 | 13,524,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,425,000.00 | 2,804,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,425,000.00 | 2,804,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,844,200.00** | **1,518,400.00** |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 35,600.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 128,300.00 | 80,960.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 38,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,600,000.00 | 1,406,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 42,300.00 | 31,440.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **13,698,300.00** | **7,015,010.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,698,300.00 | 7,015,010.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | - |
| 220001 | Барилга байгууламж | | |
| 221001 | Их засвар | | |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,007,790,400.00** | **952,071,925.29** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **35,401,700.00** | **33,748,797.00** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 35,401,700.00 | 33,748,797.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 946,980,200.00 | 918,323,128.29 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 946,980,200.00 | 918,323,128.29 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 25,408,500.00 | - |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 25,408,500.00 | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 25,408,544.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 18,447,373.29 |

| | | | |
|---|---|---|---|
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **34** | **35** |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 27 | 27 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 6 | 7 |
| 620004 | Гэрээт ажилтан | | |
| **64** | **ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО** | - | 2,559.00 |
| 640001 | Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо | | 675.00 |
| 640002 | Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо | | 1,884.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **34** | **35** |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 28 | 28 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 6 | 7 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Толбо сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний хүрээнд сумын хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан төрөөс өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон үндсэн мэргэшлийн зарим нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг иргэн, гэр бүл, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор харьяалах нутаг дэвсгэрт байгаа хүн бүрд нь нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүйгээр үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг аймгийн Эрүүл мэндийн газрын харьяа байгууллага юм.

Тайлант онд "Үйлчлэх хүрээний хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш, чанартай, хүртээмжтэй, чирэгдэл хүлээгдэлгүй үр дүнтэй үзүүлэх" зорилго дэвшүүлэн ажилласан байна. Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Хамт олны оролцоог хангах
- Үйлчлүүлэгчдийг дээдлэх
- Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах
- Ил тод нээлттэй байх
- Шинэ санаа санаачилгыг дэмжих

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Толбо сумын Эрүүл мэндийн төв нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль болон бусад эрүүл мэндийн

байгууллагуудад мөрдөж байгаа бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайланд хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас төвийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 0.3 сая төгрөгийн акт тогтоож, барагдуулж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Толбо сумын Эрүүл мэндийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2020 оны “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг батлах тухай” 19 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 397.2 сая төгрөгөөр буюу 33.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 25,408.54 | 18,447.37 | (6,961.17) |
| Авлага | - | 27,344.44 | 27,344.44 |
| Урьдчилж гарсан зардал | | | - |
| Бараа материал | 82,053.20 | 66,644.86 | (15,408.33) |
| Үндсэн хөрөнгө | 676,876.47 | 1,069,109.35 | 392,232.89 |
| **Нийт хөрөнгө** | **784,338.20** | **1,181,546.03** | **397,207.83** |
| Өр төлбөр | | | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 784,338.20 | 1,181,546.03 | 397,207.83 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **784,338.20** | **1,181,546.03** | **397,207.83** |

*Эх сурвалж: Аудитын судалгаа*

Мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгийн дансуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эцэст 18.4 сая төгрөг болж оны эхнээс 7.0 сая төгрөгөөр буурсан нь оны эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Авлага данс оны эхэнд үлдэгдэлгүй, оны эцэст 27.3 сая төгрөгийн авлагатай гарсан нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах төлбөртэй үйлчилгээний авлага байна.

Бараа материал дансны үлдэгдэл оны эцэст 66.6 сая төгрөг болж 15.4 сая төгрөгөөр буурсан нь 177.4 сая төгрөгийн материал худалдан авч, ЭМГ-аас 8.2 сая төгрөгийн эм боох, 9.3 сая төгрөгийн аж ахуйн материал үнэ төлбөргүй хүлээн авч, 182.7 сая төгрөгийн бараа материал зарцуулж, 27.6 сая төгрөгийн эм, аж ахуйн материалыг акталж данснаас хассан байна.

Тус төв нь ЭМЯ-наас 2022 онд 52.0 сая төгрөгийн, 2023 онд 8.2 сая нийтдээ 60.2 төгрөгийн үнэ төлбөргүй эм, эмнэлгийн хэрэгсэл хүлээн авснаас төвийн даргын тушаалаар баталсан хагас, бүтэн жилийн тооллогын комиссын шийдвэрээр хадгалах хугацаа дууссан, ашиглах боломжгүй 21.9 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг устгалын комисс нь зурагжуулан баримтжуулж акталж устгасан байна.

Үндсэн хөрөнгийн данс 392.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 32.1 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 415.9 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгөнд тайлант онд 55.7 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөр данс оны эхэн, ба эцэст өглөггүй.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант оны 397.2 сая төгрөгийн үр дүнтэй гарсантай холбоотой 397.2 сая төгрөгөөр өссөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ЭМД-ын сангаас 1254.7 сая, орон нутгийн төсвөөс 35.4 сая, нийт зарлагыг 1290.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төвийн 2023 оны ЭМД-ын сангаас авах төсвийг 947.0 сая төгрөгөөр хянаж баталсан.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 35.4 сая төгрөгөөр баталж, тодотголоор өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 947.0 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 35.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийтдээ 982.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 947.0 сая, орон нутгийн төсвөөс 35.4 сая нийтдээ 982.4 сая төгрөгийн санхүүжилт авч, 25.4 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс зарцуулсан байна. Оны эцэст орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтээс 1.7 сая төгрөгийг хэмнэж төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 959.0 сая төгрөг буюу 95.2 хувьтай буюу мөнгөн хөрөнгийн дансанд 18.4 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **1** | **71601-Нийгмийн эрүүл мэнд** | | | | |
| | 80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 35,401.70 | 33,748.80 | 1,652.90 | 95.3 |
| **2** | **71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ** | | | - | |
| | 80302-Нэг иргэнд ноогдох нормативаар | 653,783.40 | 639,028.92 | 14,754.48 | 97.7 |
| | 81603-Үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээ | 293,196.80 | 261,088.91 | 32,107.90 | 89.0 |
| | 83603-Дээд шатны төсвөөс хуваарилсан | 25,408.50 | 25,166.48 | 242.02 | 99.0 |
| | **Дүн** | **1,007,790.40** | **959,033.10** | **48,757.30** | **95.2** |

*Эх сурвалж: Аудитын судалгаа*

Төсвийн гүйцэтгэл нь төлөвлөснөөс 48.8 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарчээ. Үүнд: цалингийн зардал 20.8 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1.6 сая, хангамж, бараа материалын зардал 6.3 сая, нормативт зардал зардал 6.3 сая, эд хогшил, урсгал засварын зардал 6.3 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардал 0.3 сая, бараа үйлчилгээний бусад зардал 6.7 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй байгаа нь төсвийн төлөвлөлт үндэслэлгүй төлөвлөгдсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Эрүүл мэндийн төв нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Толбо сумын Эрүүл мэндийн төв 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Толбо сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 177.4 сая төгрөгийн бараа материал, 32.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн №17 дугаар албан бичгээр ирүүлсэн.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Толбо сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 748.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 11.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгав. Тус Эрүүл мэндийн төв нь 2023 онд нийт мэдээлэх хугацаа болсон 154 мэдээлэл, 937.0 сая төгрөгийн орлого, зарлагын мэдээллийг, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 8 шийдвэрийг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100%-тай байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус Эрүүл мэндийн төв нь 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 152.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 заалт бүхий зөвлөмж өгсөн. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг давтан шалгаж үзэхэд 2 зөрчлийг бүрэн арилгаж, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа байгаа тул биелэлтээр тооцов.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 3 | 152,132.3 | 3 | 152,132.3 | 100% |
| **Нийт дүн** | **3** | **152,132.3** | **3** | **152,132.3** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц онц асуудал байхгүй боловч санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайлагнал, санхүүгийн баримтыг түүврийн аргаар эрсдэлд тооцож үзсэн тул хөтөлбөр арга хэмжээний зардлууд болон төсвийн гүйцэтгэлийн зарцуулалтыг үзэх шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар нийт 15.8 сая төгрөгийн зөрчил[1] илэрч зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*1.1.Илрүүлэлт*:

Сумын Засаг даргын захирамж болон Эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар цалингийн зардлаас ажилтнуудад 15.8 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”-тай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цалингийн зардлаас ангилал зөрчиж түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон. | 1 | 15,750.0 | | | | | 1 | 15,750.0 | | | | |
| **Дүн** | **1** | **15,750.0** | | | | | **1** | **15,750.0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |